

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2020 ОНЫ 01/1004АВЛИГЫН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

/2020 оны 09 дүгээр сарын 09-ний байдлаар/

№	Зөвлөмж	Зөвлөмжид дурдсан асуудал, арга хэмжээ	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ /асуудал бүрээр/	Дүн шинжилгээ	Цаашид авах арга хэмжээ	Хувь
	1	2	3	4	5	6
1	Авлигатай тэмцэх газрын 2020оны 01/1004 зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө гарган баталгаажуулах	-	Авлигатай тэмцэх газрын 2020оны 01/1004 Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2020 оны А/142 тоот захирамжаар батлуулан сум, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах	Зөвлөмж хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр батлуулан хэрэгжүүлэх	100
2	Хуульд эрх хэмжээ олгогдооүй байхад хэм хэмжээний актыг тогтоон мөрдүүлэх, хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхгүй байх, хуулиар хэм хэмжээний акт тогтоох эрхгүй этгээд дүрэм, журам батлан мөрдүүлэх, зөрчил арилахгүй, давтагдан гарсаар байгааг таслан зогсоож, урьдчилан сэргийлэх, захиргааны хэм хэмжээний актад	Авлигатай тэмцэх газраас Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын гишүүд, салбарын сайд, аймгуудын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт 2017-2019 онуудад хүргүүлсэнЗӨВЛӨМЖ-д дурдсан асуудлууд бүрэн шийдвэрлэгдээгүй, зөрчил, дутагдал дахин илэрсээр байна: 1)Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т“Хуульд заасан хязгаар,	Улсын нэгдсэн санд бүртгэлтэй аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20, аймгийн Засаг даргын 1 захиргааны хэм хэмжээний акт байгаа бөгөөд одоогоор нэмэлт, өөрчлөлт хийгдээгүй хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй актын тулгалт судалгааг хийж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтэст аймгийн Засаг даргын албан тоотоор хүргүүлсэн. 2020 оны 9 сарын байдлаар аймаг, сумдын Засаг даргаас хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд захиргааны хэм	Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах	Цаашид энэ зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	70

	<p>мониторинг, үнэлгээ хийж, зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах.</p>	<p>шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох” эрхийг зөвхөн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд олгосон байхад дээрх заалтыг зөрчин иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид өөрт олгогдоогүй эрхийг хэрэгжүүлж, шийдвэр гаргасан;</p> <p>2)Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэгт “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална” гэж заасныг мөрдөөгүй, мөн хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх заалтыг хэрэгжүүлдэггүй;</p> <p>3)Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан “Энэ хуулийн ... 27.1.1, 27.1.4-27.1.6 дахь заалт, 27.2-27.4 дэх хэсэг, ... -т заасан тэмдэгтийн хураамжийнхэмжээг энэ хуульд заасан хязгаарт багтаан Засгийн газар</p>	<p>хэмжээний акт батлан гаргаж Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлээгүй байна.</p>			
--	---	---	---	--	--	--

		<p>тогтооно.” гэж заасан байтал уг хэмжээг Засгийн газар бус Эрүүл мэндийн сайд (“Тэмдэгтийн хураамжийн төлбөрийн хэмжээ, зардлын жишиг”) баталсныг эргэж нягтлах, хуульд нийцүүлэхтэй холбоотой зөвлөмжийг АТГ-аас Засгийн газар, Эрүүл мэндийн сайдад хүргүүлсэн боловч холбогдох арга хэмжээг авалгүй орон нутагт мөрдсөөр байгаа; 4) Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааныхэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг цаашид авах арга хэмжээний талаарх саналын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг үр дүнтэй хэрэгжүүлдэггүй зэрэг болно.</p>				
3	<p>Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, урьдчилан төлөвлөж урсгал зардлаар хийж болох үйл ажиллагааг</p>	<p>Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 зарим</p>	<p>Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалыг удирдлага болгон Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулж байгаа бөгөөд 2020 онд 302.351.400 төгрөг батлагдсанаас 2020 оны 09 дугаар сарын 01-ний байдлаар нийт</p>	<p>Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах</p>	<p>Засаг даргын нөөц хөрөнгийг хэт үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж</p>	70

	санхүүжүүлдэг зөрчил дутагдлыг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, зориулалтын дагуу зарцуулах, хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авах, уг хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд тайлагнах, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах.	зүйл, хэсэг, заалт нь албан тушаалтанд төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулах боломжийг бүрдүүлсэн ба Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлага (захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй)-ыг хангаагүй хууль бус захиргааны актыг мөрдсөөр байна. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс Улсын баяр наадам тэмдэглэх, зочид төлөөлөгч хүлээн авах, шагнал, урамшуулалд зарцуулдаг явдлыг таслан зогсоож, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх, хариуцлага, хяналтыг чангатах арга хэмжээ авах нь зүйтэй.	49 захирамжаар 300.148.970 төгрөгийг зарцуулж 2.202.430 /0,06 хувь/ төгрөгийн үлдэгдэлтэй байна. Гарсан зардлуудыг дурдвал ЗДНХ-ийн журмын 2.1.1 дэхь заалтын хүрээнд байгалийн гамшиг, осол, үр дагаварыг арилгах зардалд 176,2 сая төгрөг буюу 58,2 хувь, 2.1.3 дахь заалтын хүрээнд Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд урьдчилан төсөвлөж төсөвт тусгах боломжгүй нэг удаагийн арга хэмжээний зардал болон иргэд, байгууллагаас тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардалд 123,9 сая төгрөг буюу 40,9 хувийг тус тус зарцуулсан байна.		байгаад хяналт тавих, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авах	
4	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, төлөвлөлт болон гүйцэтгэлийг үр ашигтай, ил тод, олон нийтэд нээлттэй болгож хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх, хууль тогтоомжийг	Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тендер, худалдан авалтын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, авлига, ашиг сонирхлын эрсдэл арилаагүй, зөвлөмж, шаардлага хүргүүлсээр байхад доор дурдсан зөрчил, дутагдал гарсаар байна: хөрөнгө оруулалтын ажлууд зураг, төсөвгүйгээр батлагдсан; тендер сонгон	Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын хэрэгжилтийг хангаж сумд, агентлагуудаас дараа онд хэрэгжүүлэх нэн түрүүнд шаардлагатай хөрөнгө оруулалтын саналыг авч нэгтгэн жил бүрийн төсөв батлахын өмнө аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, сум бүрээс сонгогдсон аймгийн ИТХ-ын төлөөлөгч, сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нартай санал солилцож эрэмбэлсэн ажлыг тусган ажиллаж хэвшсэн.	Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах	Худалдан авах ажиллагааны хууль, тогтоомж болон цахим системийн талаар мэдээлэл болон мэргэшил арга зүйн зөвлөгөөг сонирхсон этгээдэд тухай бүр	100

	<p>зөрчиж шууд худалдан авалт хийх, нэмэлт гэрээ байгуулан санхүүжилт олгодог зэрэг зөрчлийн таслан зогсоох, худалдан авалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим тендерийн үйл ажиллагааг боловсронгуй болгох</p>	<p>шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалданавах тухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангаагүй компаниудтай гэрээ байгуулсан;</p> <ul style="list-style-type: none"> •худалдан авах ажиллагааг зохион байгуулалгүйгээр гэрээ байгуулж, тендерийн баримт бичгийг нөхөн бүрдүүлсэн; •хэрэгжиж дуусаагүй, гэрээ дүгнээгүй ажил, арга хэмжээнд санхүүжилт олгосон; •төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр зохих сургалтад хамрагдаж АЗ сертификат аваагүй этгээдийг тендерийн үнэлгээний хороонд ажиллуулсан; •хууль зөрчин шууд худалдан авалт хийсэн; •тендерт хамгийн бага үнээр шалгарсан аж ахуйн нэгж нь гэрээний хугацаанд анхны үнийг дүнг нэмэгдүүлж нэмэлт гэрээ байгуулан төсвийн хөрөнгө завшсан г.м. 	<p>Мөн төсөв батлагдсаны дараа Нийтийн сонсголын тухай хуулийн дагуу сонсох ажиллагааг зохион байгуулж хэвшлээ. Батлагдсан төсвийг www.shilendans.gov.mn сайт болон аймгийн албан ёсны цахим хуудас www.selenge.gov.mn сайтад байршуулан ажиллаж байна. 2020 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусгах ажил, төсөл арга хэмжээний саналыг Сангийн яамны pims.publicinvestment.gov.mn програмд оруулсан бөгөөд үүнд зураг төсөв, ТЭЗҮ, газрын захирамж, холбогдох техникийн нөхцөл зэрэг холбогдох бичиг баримтын бүрдэл дутуу, байгууллагын үйл ажиллагааны зардлын шинжтэй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын саналд тусгаагүй болно. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д байршуулж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системээр олон нийтэд ил тод нээлттэй мэдээллэн цахимаар зохион байгуулан ажиллаж байна. 2020 онд нийт 30.3 тэрбум төгрөгийн 139 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс захиалагчаас зураг төсөв, ажлын даалгавар ирүүлсэн 124 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зарлаж, 108 төсөл арга хэмжээний гэрээ байгуулах эрх</p>		<p>өгч хэвших</p>	
--	--	---	---	--	-------------------	--

			олгосон байна. Худалдан авах ажиллагааны хууль, тогтоомж болон цахим системийн талаар мэдээлэл болон мэргэшил арга зүйн зөвлөгөөг сонирхсон этгээдэд тухай бүр өгч ажиллаж байна.			
5	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг, урт, дунд болон богино хугацааны хөгжлийн хөтөлбөр, зорилттой нийцүүлэх төлөвлөх, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хяналт мониторингийн ажлыг зохион байгуулж, үр ашгийг үнэлж, дүгнэх, ил тод байдлыг хангуулах, олон нийтэд мэдээлэх, дэвшилтэт арга хэлбэрийг нэвтрүүлэх, хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах, сайн туршлагыг солилцуулах ажлыг зохион байгуулах	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлыг төлөвлөх, батлахад иргэдийн оролцоог хангах талаар анхаарч ажиллах шаардлагатай. Хэдийгээр багийн иргэдээр хэлэлцүүлсэн гэх боловч холбогдох материалыг архивын нэгж болгодоггүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй ажлыг баталдаг зэрэг зөрчил, дутагдал арилахгүй байна. Аймаг, нийслэлийн ЗДТГ-аас https://tusuv- oronnutag.mof.gov.mn/ цахим хуудсанд Орон нутгийн хөгжлийн сангийн нүлэжиллагааны журмын 9.9-д заасан мэдээллийг бүрэн байршуулахгүй байгаад дүгнэлт хийж, 2020 оны 1 дүгээр улиралд багтаан 2013 оноос хойшхи мэдээллийг нөхөж, бүрэн байршуулах, цаашид мэдээллийг тогтмол шинэчлэх, тус сангаас хэрэгжүүлсэн төсөл арга, хэмжээ, тэдгээрийн үр ашиг,	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг, урт, дунд болон богино хугацааны хөгжлийн хөтөлбөр, зорилттой нийцүүлэх төлөвлөх, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хяналт мониторингийн ажлыг зохион байгуулж, үр ашгийг үнэлж, дүгнэх, Санхүүгийн хяналт аудитын алба хийж дүгнэлтийг ирүүлсэн. Тогтвортой амьжиргаа 3” төсөл Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилт үр дүнд мониторинг хийж бүх чадавхи бэхжүүлэх багтай хамтран явцын хяналт, зөвлөн туслах үйл ажиллагааг явуулсан.	Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах	70

		алдаа дутагдлын талаарх хэлэлцүүлгийг цахимаарболон бусад хэлбэрээр өрнүүлж, олон нийтэд мэдээлэх ажлыг хэвшүүлэх ажлыг тус тус зохион байгуулах шаардлагатай.				
6	Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбогдуулан хүргүүлсэн өмнөх зөвлөмжид дурдсан зөрчлүүд давтагдан гарч байгааг таслан зогсоох, давтан гаргаж буй буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох, хохирлыг нөхөн төлүүлэх, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, олгосон зээлийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх дэвшилтэт аргыг тодорхойлж хэрэгжүүлэх, уг мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжийг олон нийтэд олгох	Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй, зээлийн эргэн төлөлт, зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьдаггүй, зээл олгохдоо барьцаа хөрөнгө авдаггүй, зээлийг буцаан төлөх төлбөрийн чадваргүй иргэнд зээл олгосонзэрэг зөрчлүүд арилахгүйбайна. Мөн Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, түүний талаарх мэдээллийг ил тод болгон сонирхогч этгээд танилцах боломж, нөхцөлийг бүрдүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна. Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаарСум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн улсын үзлэгийг 2019оны 04-р сарын 25-ны өдрөөс 05-р сарын 25-ныөдрүүдэд зохион байгуулж, дүнг 2019 оны 07 дугаар сарын 01-ний доторЗасгийн газрынхуралдаанд	1.Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2020 оны 1 дүгээр сарын 14-ний “Зөвлөн туслах” ажлын хэсгийн удирдамжийн дагуу 01-р сарын 14-өөс 30-ны хооронд Алтанбулаг, Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул, Сайхан сумдад ажилласан. Сумдын сум хөгжүүлэх сангийн зээлдэгчдийн хувийн хэргийн бүрдэлтийг шалган зөвлөгөө өгч ажилласан. Сум хөгжүүлэх сангийн зээлийг гаргахдаа аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт зээл хүссэн иргэдийн нэрсийг ирүүлж, Монгол банкны мэдээллийн сангаас давхар зээлтэй эсэх талаарх лавлагааг авч ажиллаж байна. Ингэснээр зээлийн давхардал арилах, чанаргүй зээлийн хувь хэмжээ буурсан үзүүлэлттэй байна. Сумдын сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах онлайн сургалтыг 2020 оны 6 дугаар сарын 03-нд өдөр аймгийн хэмжээнд зохион байгууллаа. Сургалтаар сум хөгжүүлэх сангийн зээл олголтонд баримтлах зөрчим, барьцаа хөрөнгийн гэрээ байгуулж ажиллах	Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах	70

		<p>танилцуулахаар шийдвэрлэсэн. Улсын үзлэгийг заасан хугацаанд явуулсан боловч үр дүнг тайлагнах ажил хийгдээгүй тул үүргийн биелэлтийг хангах, цаашид уг сангийн үр өгөөжийг дээшлүүлэх, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, өр төлбөрийг барагдуулах, мэдээллийн сангийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг олгох чиглэлээр дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй</p>	<p>талаар заалтыг тусгах зэргээр зөвлөмж чиглэлийг өглөө. 2.Сумд сум хөгжүүлэх сангийн эх үүсвэр бүрдсэн тохиолдолд төсөл сонгон шалгаруулах зараа олон нийтэд зар болон социал хэлбэрээр хүргэж, зээл хүссэн иргэдээр төслийг нь ил тод нээлттэй хамгаалуулан ажиллаж байна. Мөн зээл авсан иргэдийн мэдээлэл, хугацаандаа зээлээ төлөхгүй байгаа иргэдийг орон нутгийн цахим сайт болон сумын Засаг даргын Тамгын газрын зарын булангаар тогтмол мэдээлэн ажиллаж байна.</p>			
7	<p>Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, сурталчлах ажлыг тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулах. Ялангуяа Засаг дарга хуулиар хүлээсэн өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг доод шатны байгууллага, албан тушаалтанд шилжүүлэхгүйгээр эцэслэн хариу өгөх</p>	<p>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль батлагдаад удаж байна. Өнгөрсөн 25 жилийн хугацаанд 5 удаагийн хуулиар хэд, хэдэн нэмэлт, өөрчлөлт орсон байдаг. Цаг үе, нийгмээ дагаж төр, иргэний харилцаа ч мөн адил хувьсан өөрчлөгдөж байгаа тул хуулийн зохицуулалт өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу гэдгийг судлан үзэх шаардлагатай. Авлигатай тэмцэх газраас 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран төрийн байгууллагын</p>	<p>Аймгийн хэмжээнд 2020 онд зохион байгуулагдахаар тусгагдсан ажил, арга хэмжээ, түүний холбогдох мэдээллийг орон нутгийн мэдээллийн хэрэгслүүд болон аймгийн төв талбай, сумдын ЗДТГ-ын гадна, дотор байрлах цахим дэлгэц, зурагтаар сурталчлах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Мөн аймгийн ЗДТГ-аас эрхлэн гаргадаг улирал бүрийн “ӨРГӨН СЭЛЭНГЭ” сэтгүүлээр хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээ, аймаг, орон нутгийн хэмжээнд гарч буй тогтоол, захирамж, санхүү, төсөв, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, түүний шийдвэрлэлт, агуулгын мэдээ, мэдээллүүдийг нийтлэн иргэд олон нийтэд хүргэж ажиллалаа. Аймаг, сумдын Засаг даргын хуулиар</p>	<p>Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах</p>	<p>Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах</p>	100

		<p> өргөдөл, гомдол хариуцсан ажилтнуудыг оролцуулсан “Иргэдийн өргөдөл, гомдол: Шийдвэрлэлт, хяналт, тайлагналт” сэдэвт форумыг анх удаа зохион байгуулсан. Энэхүү форумын зорилго нь иргэний гомдлыг шуурхай шийдвэрлэх, хяналт тавих боломжийг хангах, төрийн албан дахь хүнд суртлыг багасгах, авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, ялангуяа иргэдээс хүлээн авч буй өргөдөл, гомдлын агуулга, хянан шалгах явц, шийдвэрлэлтэд хийх дүн шинжилгээний чанар, арга зүйг сайжруулахад чиглэж, төрийн байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах явдал байсан. Төрийн байгууллагууд хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах ажлыг тасралтгүй хийх ажил хангалтгүй байгаагаас хамааран иргэд тухайн нэг асуудлаар хаана, хэнд хандахаа мэдэхгүй байх тохиолдол гардаг нь иргэдийн бухимдлыг төрүүлдэг, мөн иргэдээс төрийн эрх бүхий </p>	<p> хүлээсэн чиг үүргийн хүрээнд орон нутгийн ард иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч төсөв, санхүү болон бусад нөөц бололцоогоо ашиглан чиг үүргийн хэмжээнд шийдвэрлэж байна. Мөн иргэдийн ирүүлж буй өргөдөл, гомдлын агуулгад дүн шинжилгээ хийж түүнийг тухайн жилийн аймаг, орон нутгийн төсөвт тусгуулан шийдвэрлэж байна. Үүний үр дүнд аймгийн хэмжээнд иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлын тоо буурсан үзүүлэлттэй гарч байна. </p>			
--	--	--	--	--	--	--

		дээд шатны байгууллагад хандсан асуудлыг хянаж үзэж шийдвэрлэхгүйгээр доод шатны байгууллагад шилжүүлэх явдал хэвшмэл болсон нь иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулах хүчин зүйл болж байна.				
8	Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан орон нутгийн өмч, хөрөнгө, төсөв, мөнгө, хүн хүчийг улс төрийн үйл ажиллагаа, сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй байхад онцгойлон анхаарч, аливаа ашиг сонирхлын зөрчил гаргах, авлигын асуудал үүсгэхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавьж ажиллах		Улсын Их Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдуулан орон нутгийн өмч, хөрөнгө, төсөв, мөнгө, хүн хүчийг улс төрийн үйл ажиллагаа, сонгуулийн сурталчилгаанд ашигласан тохиолдол гараагүй. Төрийн албан хаагчдыг нам, улс төрийн болон авлига, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ажилд хяналт тавьж ажиллаж байна.	Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах	100
9	Аймаг, сумын Онцгой комисст “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” гэсэн хуулийн		Коронавируст /Covid-19/ халдвараас урьдчилан сэргийлэхтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас аймаг, сумдын Онцгой комисс, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар зэрэг зарим төрийн байгууллагуудад хандив өгч байгаа нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах,	Зөвлөмжийн хэрэгжилт ханган ажиллах	Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллах	100

	<p>заалтыг хэрэгжүүлэхээр зохицуулалттай тул хандив, бэлэг авах талаар зөвлөмж, үүрэг чиглэл өгөх</p>		<p>ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу “албан тушаалтан албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтныг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг авч болно” гэж заасантай зөрчилдөж байгаатай холбогдуулан дээрх хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасны дагуу “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр зохицуулалттай тул Улсын онцгой комисст хандан зөвшөөрөл хүссэн авбан тоотыг хүргүүлэн ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Чиглэл өгөх тухай” ЗГ-2/248, Авлигатай тэмцэх газрын 2020 оны “Зөвлөмж хүргүүлэх тухай” 01/2634, 01/4291, дугаартай албан тоотуудыг аймгийн Засаг даргын 2020 оны 01/307, 01/308 албан тоотоор сум, агентлагуудад хүргүүлэн чиглэл өгч ажилласан.</p>			
			<p>Дундаж үнэлгээ – 86.6%</p>			<p>86.6%</p>

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР